

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ
ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТТАЙ
ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ ӨМНӨХ ОНООС БУУРСАН БАЙНА”**

АУДИТЫН КОД: /НАГ-2020/02/-НА/

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор О.Ганболд
Утас: 7038-4793, Цахим хаяг: Ganboldo@audit.gov.mn

Ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ
Утас: 7038-4043, Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор Н.Гүрбазар
Утас: 7038-4043, Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn

Аудитор З.Даваадорж
Утас: 7038-4043, Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Хөвсгөл аймаг
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: audit.mn/?page_id=579



Тайланг бэлтгэсэн:

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын
газрын Нийцлийн
аудитын алба**

**Тэргүүлэх аудитор
О.Ганболд
Утас: 99382500**

**Аудитын менежерийн
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч**

**Э.Бат-Эрдэнэ
Утас: 88090438**

Багийн гишүүд:

**Ахлах аудитор
Э.Бат-Эрдэнэ**

**Аудитор
Н.Гүрбазар
З.Даваадорж**

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70384043. 70384044
дугаарын утсаар
харилцана уу.

**Тайланг УАГ-ын веб
сайт-аас үзнэ үү.
www.audit.mn**

ХАЯГ:
Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус
3 давхар

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, хугацаа арга зүй
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт
Үндсэн мэдээлэл

**БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ
ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ,
БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.**

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,407.4 сая
төгрөгийг хуваарилсан байна.

1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтийг хуваарилахдаа
Төсвийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн
хуваарилсан байна.

**БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ
ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН
БАЙНА.**

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний
төлөвлөлттэй холбоотой зөрчил нь өмнөх онтой харьцуулахад
буурсан үзүүлэлттэй байна.

2.2. Аймаг, сумын 2019 оны ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу
зарцуулсан байна.

**БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДААС
ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАСАН Ч ҮР ДҮНГ ТООЦОН, НИЙТЭД
МЭДЭЭЛЭЭГҮЙ БАЙНА.**

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга
хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад эрх бүхий
байгууллагууд хяналт тавьж ажилласан байна.

3.2. ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн явцыг журамд
заасны дагуу хугацаанд нь тайлагнасан боловч аймгийн Засаг
даргад үр дүнг танилцуулаагүй байна.

3.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт
86.5 хувьтай байна.

4. Дүгнэлт

5. Зөвлөмж

6.Зөрчлийн жагсаалт

7. Холбогдох байгууллагын санал, саналд өгөх тайлбар

8. Тайлан баталгаажуулах тушаал

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ХөТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
НАТ	Нөөц ашигласны төлбөр
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
НӨАТ	Нэмэн өртгийн албан татвар
ТА-3	Тогтвортой амьжиргаа-3
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ШХА	Шууд худалдан авалт
ОНО	Олон нийтийн оролцоотой
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/53 дугаартай тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж аудитын тайлан, дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэх, аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.Үүнд:

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;
- ❖ Өмнөх аудитаар тогтоогдсон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Хөвсгөл аймгийн хэмжээн дэх орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналтыг, холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

Аудитад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс мөн Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газар; сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Баг хорооны Засаг дарга, иргэд Нийтийн Хурал болон бусад холбогдох газруудыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100 дугаар стандартууд болон MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан” Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, аймгийн ЗДТГ-ын СТСХ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, сумдын ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч болон холбогдох албан

тушаалтантай уулзалт ярилцлага хийх, иргэдээс санал асуулга авах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврын холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- ❖ Төрийн аудитын тухай хууль;
- ❖ Захиргааны ерөнхий хууль;
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль;
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ❖ Зөрчлийн тухай хууль;
- ❖ Шилэн дансны тухай хууль;
- ❖ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоол
- ❖ Монгол Улсын сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”;
- ❖ Монгол Улсын сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”;
- ❖ Монгол Улсын сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”;
- ❖ Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “2019 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоол
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам;

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Ганболд хянан удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Бат-Эрдэнэ явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитор Н.Гүрбазар, З.Даваадорж нар 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 2020 оны 11 дүгээр сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан¹ Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байсныг Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулахаар өөрчилсөн байна.

Сангийн сайдын 2014 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын” 6.1.1²-д заасан ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1.3³ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60.2⁴ дахь заалтад нийцүүлэн Хөвсгөл аймгийн 2019 оны ОНХС-ийн эх үүсвэрийг Сангийн яам холбогдох журамд заасан нэр төрөл тус бүрээр тооцож 8,407.4 сая төгрөгийг хуваарилсан байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг 2020 оныг хүртэлх хугацаанд хэрэгжиж байна.

“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 2019 онд 23 сум, 1 тосгоны ОНХС-д 803,6 сая төгрөгийн дэмжлэг, 488,7 сая төгрөгийн урамшуулал нийт 1,292.3 сая төгрөгийг олгосон байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд буюу 2019 оны 04 дүгээр сард хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудитаар нийт 5,175.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг арилгах цаашид давтан гаргахгүй байх тухай 15.9 сая төгрөгийн 9 албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

¹ Цаашид Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” гэх

² орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг;

³ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг санхүү, төсвийн асуудал харцуцсан төрийн захиргааны төв байгууллага тооцно.

⁵ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.


БҮЛЭГ 1:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.

Дэд бүлэг-1.1: Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,407.4 сая төгрөгийг хуваарилсан байна.

Хөвсгөл аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг Сангийн яам 2018 онд 5,455.4 сая төгрөгөөр хуваарилж байсан бол 2019 онд 8,407.4 сая төгрөгөөр хуваарилсан байна. Өмнөх онтой харьцуулахад ОНХС-ийн эх үүсвэр 2,952.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 2018 он, 2019 онд олгосон гүйцэтгэл буюу Хөвсгөл аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийн харьцуулсан үзүүлэлтийг графикаар харуулбал: **График №1 /сая.төг/**



Дэд бүлэг-1.2: Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтийг хуваарилахдаа Төсвийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн хуваарилсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХНС-аас хуваарилагдсан 8,407.4 сая төгрөгийн эх үүсвэр дээр аймаг, сумдын ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 1,004.3 сая төгрөг зарим сумдын орон нутгийн давсан орлогоос 52.6 сая төгрөгийг нэмж батлан аймгийн хэмжээнд нийт 9,464.3 сая төгрөгийн эх үүсвэр бий болсон байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор ОНХНС-аас шилжиж ирсэн хөрөнгийг батлан хууль журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна. **Тодруулбал:** Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцож, хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2⁵, МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоол “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8 дугаар зүйлд заасны дагуу тухайн сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн

⁵ Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг харгалзан хуваарилсан байна. Дүрсэлж харуулбал: **Дүрслэл №1**



Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг МУЗГ-ын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.5⁶-дахь заалтад заасан хугацааг баримтлан аймгийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 2:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулсан байна.

Дэд бүлэг-2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой зөрчил нь өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд: Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 3-р хавсралтаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд шинээр хэрэгжүүлэх 15 ТАХ-нд 1,848.6 сая төгрөг, өмнөх оноос шилжих 8 ТАХ-нд 2,425.8 сая төгрөг, ОНХС-аас санхүүжих суурь зардалд 962.4 сая төгрөг нийт **5,236.8** сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ОНХС-ийн хөрөнгийн төсөвт тодотгол хийж 613.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тодотголоор дараах ТАХ-ний санхүүжилтийг нэмж баталсан байна. Хүснэгтээр харуулбал: **Хүснэгт №1**

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Хэрэгжсэн эсэх	Тайлбар
Өмнөх оноос шилжсэн төсөл, арга хэмжээ /Тодотголоор нэмсэн/				
1	100 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих	7.7	Хэрэгжээгүй	Шинээр
2	Баяр наадмын талбайн засвар /нэмэлт ажил/	124.4	Хэрэгжсэн	Шинээр
3	Титэм сургуулийн спорт заалны хүзүүвчийн барилга ус, ариун цэврийн байгууламж барих ажлын дуусгалт	5.7	Хэрэгжсэн	Санхүүжилт нэмсэн
4	Орон сууцны байруудын гадна фасад, орцны засварын ажлын дуусгалт	8.5	Хэрэгжсэн	Санхүүжилт нэмсэн
5	Гудамжны гэрэлтүүлгийн дуусгалт	17.7	Хэрэгжсэн	Санхүүжилт нэмсэн
6	Мөрөн сумын богино холболтын авто замуудыг хатуу хучилттай болгох шинэчлэлийн ажлын дуусгалт	220.8	Хэрэгжсэн	Санхүүжилт нэмсэн

⁶ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг ажлын 3 хоногийн дотор сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хуваарилна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитын тайлан


НАГ-2020/02/НА

7	50 100 энергийн төв цогцолборын сайжруулсан авто замын ажил явган хүний гүүр, хөшөө дурсгалын ажлын дуусгалт	1.1	Хэрэгжсэн	Санхүүжилт нэмсэн
Дүн:		386.0		
Шинээр хэрэгжүүлэхээр /тодотголоор нэмсэн/				
1	Нийтийн тээврийн үйлчилгээ /Мөрөн сум/ хүүхдийн үйлчилгээнд 5 автобус худалдан авах	175.0	Хэрэгжээгүй	Шинээр
2	Төв гудамж, захын хорооллын гэрэлтүүлгийн засвар	46.0	Хэрэгжсэн	Шинээр
3	Аймгийн төвийн камержуулалтын үйл ажиллагаанд засвар үйлчилгээ хийх	6.0	Хэрэгжсэн	Шинээр
Дүн				227.0
НИЙТ ДҮН				613.0

Өмнөх онд бүрэн хэрэгжээгүй, санхүүжигдээгүй 10 ТАХ-г Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6.2⁷, 6.8⁸ дахь заалтуудад нийцүүлэн 2019 онд 2,811.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-г дараах байдлаар төлөвлөсөн байна. Диаграммаар харуулбал: **Дүрслэл №2**

2019 ОНЫ ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний урьдчилсан жагсаалтыг төлөвлөхдөө “Хөгжсөн Хөвсгөл 2030”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаатай уялдуулан боловсруулсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний урьдчилсан жагсаалтыг боловсруулахдаа сумдын иргэдээс авсан саналаас Төсвийн тухай хууль болон, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т заасан аймгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах саналуудыг нэгтгэн эрэмбэлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/463 дугаар захирамжаар байгуулагдсан “Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах” ажлын хэсэг нь нийтийн сонсголыг зохион байгуулахдаа аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний

⁷ “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр дараа жил хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаа, урьд онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг харгалзан боловсруулна”

⁸ “ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж, ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулна”

төлөвлөлт, санал асуулгын эрэмбэлэлт, холбогдох албан тушаалтан, иргэд олон нийтийг нээлттэйгээр оролцуулан ил тод байдлыг хангаж ажилласан байна.

Сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд: Аудитад хамрагдсан сумд Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврын 5.2⁹-д заасан хугацаанд багтаан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ-ний жагсаалтыг баг, хорооны ИНХ-аар хэлэлцэх, санал хураах хурлыг 5 дугаар сард багтаан зохион байгуулсан байна.

Сумдын ЗДТГ-ын захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2¹⁰ дахь заалттай нийцээгүй байна. Хүснэгтээр харуулбал.

Хүснэгт № 2

№	Сумын нэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/
1	Бүрэнтогтох сум	Хоггүй сум журмыг хэрэгжүүлэх /хогны автомашины засвар үйлчилгээ/	3.0
2	Мөрөн сум	Лейд дэлгэц суурилуулах суурийн зураг төсөв	0.3
3	Жаргалант сум	ЗДТГ-ын иргэний танхимын сандал ширээ нийлүүлэх	0.8
4	Эрдэнэбулган сум	Өлийн давааны зам засварын ажил	10.0
5		Засаг даргын бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	15.2
6	Баянзүрх сум	Нарангийн булангийн бирвазны харуулын байр барих	1.0
7		Хил хамгаалах туслах хүчний салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах	2.0
8		Иргэний боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөдөөгийн багуудад нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах	1.5
9		ЗДТГ тавилга авах	1.8
Нийт дүн			35.6

2018 оны тухайд аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлэгдээгүй 2,704.5 сая төгрөгийн 5 ТАХ-г хэрэгжүүлсэн зөрчил илэрсэн бөгөөд 2019 онд иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлэгдээгүй 35.6 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөн хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн төлөвлөлттэй холбоотой зөрчил буурсныг харуулж байна.

⁹ Баг, хорооны ИНХ-ын /цаашид Нийтийн хурал гэх/ дарга ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг жил бүрийн 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

¹⁰ Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх

Дэд бүлэг-2.2: Аймаг, сумдын 2019 оны ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 376 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, баталснаас 334 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулсан байна.



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт 376 төсөл, хөтөлбөр арга хэмжээний 325 төсөл, хөтөлбөр арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн, 9 ТАХ нь дутуу хэрэгжсэн, 42 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь Төсвийн тухай хуулийн 58.2¹¹ дахь заалт болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2¹²-т заасан чиг

үүрэгтэй нийцэж байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуулийн 29.4¹³, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 4.7-д заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь боловсруулагдсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын тухайд: ОНХС-ийн хөрөнгөөс 2019 онд 33.0 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 58.4¹⁴ дэх заалт болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 7.4¹⁵-д заасан чиг үүрэгтэй нийцээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/
1	Бүрэнтогтох сум	Хоггүй сум журмыг хэрэгжүүлэх /хогны автомашины засвар үйлчилгээ/	3.0
2	Мөрөн сум	Лейд дэлгэц суурилуулах суурийн зураг төсөв	0.3
3	Цагаан-Уул сум	“Сум дундын эмнэлгийн ор солих”	1.0
4	Баянзүрх сум	Хогны машиныг засварлаж хэвийн үйл ажиллагаатай болгох	5.0
5	Ханх	ЗДТГ-т тоног төхөөрөмж	7.0
6	Эрдэнэбулган	Засаг даргын бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	15.2
7		Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг шинээр нэмж ажиллах ажлын санхүүжилтээс зураг төсвийн мөнгийг гэрээнд заасны дагуу суутгаагүй байна.	1.5
Нийт дүн			33.0

¹¹ Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

¹² Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх.

¹³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁴ Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ:

¹⁵ Сум ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.4-т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна. Үүнд:

- ❖ **Цагаан-Уул сум:** Улсын төсвийн хөрөнгөөр баригдах “Эмэгтэйчүүд, гэр бүл хүүхэд хамгааллын хөгжлийн ордон, ЗДТГ-ын байрны техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх зураг төсөл”-ийн үнэд 8.0 сая төгрөгийг
- ❖ **Түнэл сум:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах Түнэл сумын ЗДТГ-ын барилгын зураг төсөвт 15.0 сая төгрөгийг
- ❖ **Ханх сум:** Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хяналтын камер”-ийн санхүүжилтэд 6.9 сая төгрөгийг, Сумын ЗДТГ-ын барилгын зураг төсвийн үнэд 1.2 сая төгрөгийг
- ❖ **Эрдэнэбулган сум:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах Эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөвт 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан зааврын 7.4.7 а Зураг төсөв (зөвхөн ОНХС-аас санхүүжүүлэхээр заасан төсөл, арга хэмжээний) дахь заалттай нийцэхгүй байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгийг зураг төсвийн зардалд зарцуулж болох эсвэл болохгүй талаар тодорхой тусгаагүй байна.

Энэ нь ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний зураг төсвийн зардлаас гадна өөр бусад төрлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний эх үүсвэрт зарцуулж болох нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Ихэнх сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна.

Сумдын тухайд: Дараах сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгаагүй, захиалагч ажлын гүйцэтгэлийн явцад хяналт хийгээгүй, барьцаа хөрөнгийг хуульд заасан хэмжээгээр байршуулаагүй байна. **Үүнд:** Алаг-Эрдэнэ сум, Арбулаг сум, Бүрэнтогтох сум, Галт сум, Цэцэрлэг сум, Цагаан-Уул сум, Цагаан-Үүр сум, Шинэ-Идэр сум, Чандмань-Өндөр сум

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-д заасны дагуу захиалагч талаас захиалагчийн хяналт, барьцаа хөрөнгийг гэрээнд тусгаж, гүйцэтгэлд үр дүнтэй хяналт тавьж хэвшээгүйг харуулж байна. Нөгөөтэйгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь зураг төсөв, техникийн тодорхойлолтод заасны дагуу чанартай үр дүнтэй хэрэгжихгүй байх нөхцөлийг бий болгож байна.

Цаашид төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, барьцаа хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр гэрээнд тусгаж байх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.7¹⁶ дахь заалтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл, арга хэмжээний урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэргүй болсон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр бий болгосон хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

ОНХС-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягт, аргачлалын дагуу гаргасан байна. Сумдын ОНХС-ийн тайланг тусад нь гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнасан байна.


Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 8.6-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалттай холбоотой мэдээллийг цахим хуудаст нийтэд ил тод мэдээлсэн байна.

Аймгийн ОНХС болон 23 сум, 1 тосгоны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-т тогтоосон хугацаанд нийтэд ил тод мэдээлсэн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 378 төсөл, арга хэмжээг төлөвлөн 316 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.



Аймгийн тухайд:
Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 4,044.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 42 төсөл арга хэмжээнд ХАА зохион байгуулсан байна¹⁷.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх

ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хууль, журамд нийцүүлээгүй байна. Үүнд:

¹⁶ “Аймаг, нийслэл, сум дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах”

¹⁷ Тендерт оролцогчгүйн улмаас он дамжсан ХАА-г оруулаагүй болно.

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Баяр наадмын талбайн засварын ажил”-ын 124.4 сая төгрөгийн нэмэлт ажлыг 2018 онд ХАА зохион байгуулалгүйгээр “Хөвсгөл Эх” ХХК-аар гүйцэтгүүлсэн байна. ТАХ-ний санхүүжилтийг олгох зорилгоор 2019 онд ХАА-г зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁸, 45 дугаар зүйлийн 45.1¹⁹ дэх заалттай нийцээгүй байна.
2. Жаргалант, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Шинэ-Идэр, Арбулаг, Улаан-Уул, Их-Уул, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл, Цагаан-Үүр, Бүрэнтогтох, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Тариалан сумд болон Хатгал тосгоны гудамж, талбайн гэрэлтүүлгийн ажлын ХАА-ны үнийн санал ирүүлэх хугацааг 7 хоног хүрэхгүй хугацаанд тогтоосон байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.6²⁰, 36.10²¹ дахь заалтуудтай нийцээгүй байна.
3. Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын ХАА-нд зураг, төслийн техникийн нөхцөлийг боловсруулсан компани оролцсон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2²² дахь заалттай нийцээгүй.
4. Их-Уул сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл боловсруулах ХАА-нд 2.8 сая төгрөгийн үнийн санал шалгарч дээрх үнийн дүнгээр гэрээ байгуулах зөвлөмж хүргэгдсэн байхад 3.0 сая төгрөгөөр гэрээг байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2²³ дахь заалттай нийцээгүй.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд зохион байгуулсан ХАА-нд дараах нийтлэг зөрчлүүд байна. **Үүнд:**

1. Үнэлгээний хороог байгуулахдаа сумын Засаг даргын захирамжаар байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.3²⁴ дахь заалттай нийцээгүй.
2. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэхдээ баримт бичиг, материалын бүрдүүлбэрийг хангаж ажиллахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2²⁵ дахь заалттай нийцээгүй.
3. Захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгаа, зураг төсвийн үнэ зэргийг худалдан авах гэрээнд тодорхой заахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3²⁶ дахь заалттай нийцээгүй байна.

¹⁸ Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹⁹ Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

²⁰ Дэлгэрэнгүй жагсаалтад санал ирүүлэх хугацааг ажлын 7-оос доошгүй өдрөөр тогтооно.

²¹ Санал ирүүлэх хугацаа нь 60 хоногоос дээшгүй байх боловч хуулийн этгээдийн хувьд 30-аас дээш, хувь хүний хувьд 7-оос дээш хоногоор тогтоож саналын урилгад тодорхой заана.

²² Захиалагч техникийн тодорхойлолт бэлтгэхдээ тухайн тендер шалгаруулалтад оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно.

²³ «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно.

²⁴ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.

²⁵ Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ:...

²⁶ Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

БҮЛЭГ 3:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад эрх бүхий байгууллагуудаас хяналт тавьж ажилласан ч үр дүнг тооцон, нийтэд мэдээлээгүй байна.

Дэд бүлэг-3.1: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4²⁷-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод нь 23 сум, 1 тосгоноос 19 сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан боловч хяналтын үр дүнг тооцон ажиллаагүй, хэрэгжилтийг нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Дараах сумдын ИТХ сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна. **Үүнд:**

1. Галт сумын ИТХ
2. Рэнчинлхүмбэ сумын ИТХ
3. Эрдэнэбулган сумын ИТХ
4. Шинэ-Идэр сумын ИТХ
5. Хатгал тосгоны ИТХ

Тус журамд заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн ОНХС-аар хэрэгжсэн ТАХ болон 14 сумын ТАХ-ний хэрэгжилтэд хяналт хийж ажилласан байна.


Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт хяналт хийгээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5²⁸-д заасны дагуу 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр 23 сум, 1 тосгонд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээнүүдэд хяналт хийгээгүй байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” –ын 6.3²⁹-т заасны дагуу “**үнэлгээ**” өгч ажиллаагүй байна. Графикаар харуулбал:

²⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

²⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.

²⁹ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад холбогдох байгууллагуудын хяналт хийсэн хувь өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.

Дэд бүлэг-3.2: ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн явцыг журамд заасны дагуу хугацаанд нь тайлагнасан боловч аймгийн Засаг даргад үр дүнг танилцуулаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2³⁰-т заасны дагуу сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэсэн ч тус журмын 9.9³¹-д заасны дагуу дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Журмын 9.3³²-т заасны дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.

³⁰ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

³¹ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

³² Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

Дэд бүлэг: 3.3: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 86.5 хувьтай байна.

“ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой 15.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, холбогдох хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой 7 албан шаардлага өгөгдсөн бөгөөд албан шаардлагууд тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжсэн байна.

Аудитаар холбогдох албан тушаалтанд 18 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд үүнээс 15 зөвлөмж хэрэгжиж дараах 3 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. **Үүнд:**

Шат шатны ИТХ-ын дарга нарт өгсөн зөвлөмж:

1. “Сумдын ОНХС-ийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналтыг чанартай хэрэгжүүлж ил тод мэдээлж байх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. **Үүнд:** Аймгийн ИТХ, Галт сумын ИТХ, Рэнчинлхүмбэ сумын ИТХ, Шинэ-Идэр сумын ИТХ, Эрдэнэбулган сумын ИТХ, Хатгал тосгоны ИТХ.

Сумдын Засаг дарга нарт өгсөн зөвлөмж:

1. “Иргэдийн саналаар дэмжигдсэн ... хөтөлбөр, төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгах.” зөвлөмжийг дараах сумд бүрэн хэрэгжүүлээгүй байна. **Үүнд:** Бүрэнтогтох сум, Баянзүрх сум Мөрөн сум, Жаргалант сум, Эрдэнэбулган сум.
2. “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх.” зөвлөмжийг аймаг, сумд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 86.5 %-тай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан байна.
2. ОНХС-ийн 2019 оны хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалттай холбоотой зөрчил нь өмнөх оноос буурсан байна.
3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.
4. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналыг аваагүй, чиг үүрэгт нийцээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтэд эрх бүхий байгууллагуудаас хяналт тавьж ажилласан хэдий ч үр дүнг тооцон нийтэд мэдээлээгүй байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний урсгал зардлын тооцоо, цаашид төсөвт хэрхэн нөлөөлөх болон урсгал зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж, дүгнэлт гаргаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуяг-т:

1. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан, хяналтаар илэрсэн асуудлыг хэлэлцэж үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх

Аймгийн Засаг дарга Л.Ганболдод:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахад анхаарч ажиллах

Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Э.Аззаяад:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргуулж байх
2. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж байх

Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болдод:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг бүрэн мөрдөж ажиллах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах
2. Сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийх хяналтыг чанартай хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах

Сумдын Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх

Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг чанартай тогтмол хийж хэвших
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд захиалагчийн хяналтын зардал, барьцаа хөрөнгийн хэмжээ зэргийг хуульд заасан хувь хэмжээгээр тусгаж, гэрээг дүгнэж ажиллах

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

/Сая төгрөгөөр/

№	Илэрсэн зөрчлийн			Албан шаардлага		Төлбөрийн акт		Өгсөн зөвлөмж	
	Утга	Тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Бүрэнтогтох, Мөрөн, Жаргалант, Эрдэнэбулган, Баянзүрх сумдад иргэдийн саналыг аваагүй эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.	9	35.6					1	-
2	Бүрэнтогтох, Мөрөн, Цагаан-Уул, Баянзүрх, Ханх, Эрдэнэбулган сумдад ОНХС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн заавар, журамд заасан чиг үүрэгтэй нийцээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.	7	33.0					1	-
3	Ихэнх сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.	1	-					1	-
4	Захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал, барьцаа хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээгээр гэрээнд тусгаагүй байна.	1						1	
5	Зарим худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй	1	124.4					1	-
6	Аймаг, Галт, Рэнчинлхүмбэ, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумд болон Хатгал тосгоны ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй	1	-					2	-
7	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаагүй байна.	1	-					2	-
8	ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.	1	-					1	-
НИЙТ ДҮН		22	193.0					10	

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал:



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
Нутгийн удирдлагын ордон 3 давхар, Утас: 7038 3330
Э-мэйл: aimginithural@khs.gov.mn
Вэбсайт: Khovsgol Khural.mn

2020.11.10 № 2/237
төний 2020.11.09 -ны № 01/712 -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аймгийн ИТХ нь ОНХС-ийн санийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор жил бүр нэгээс доошгүй удаа Нийтийн сонголыг зохион байгуулан ажиллаж байна. 2020 онд дэлхий дахинд тархаад буй Covid-19 цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй.

Иймээс шат шатны ИТХ-ын дарга нарт өгсөн зөвлөмжөөс аймгийн ИТХ-ыг хасаж өгнө үү.

Цаашид өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



ДАРГА Ц.ГОНЧИГ

119330173

Санал-1



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
Утас: 92118688

Вэб сайт: www.khovsgol.gov.mn

2020. 11. 11 № 6/2846
танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал нийлж байгаа тул тайлангийн төслийг буцаан хүргүүлэв.

Санал ирүүлээгүй
болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Э.АЗЗАЯА





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар.
Утас: 7038 8849; 70388821, Факс: 70388848
Э-мэйл: khuvs gul-tender@khs.gov.mn
Вэбсайт: http://umch.khs.gov.mn

2020.11.11 № 1/968
танай 2020.11.09-ны № 01/713 -т

Аудитын тайлангийн төсөлд
хариу хүргүүлэх тухай

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжсэн төсөл арга, хэмжээнд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нийцлийн аудит хийж тайлангийн төслийг манай байгууллагад ирүүлсэн.

Тайлангийн төсөлд туссан 4 асуудлын хариуг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас ирүүлсэн асуудлын бүртгэлд байгууллагын санал болгон тусган холбогдох нотлох баримтын хамт хүргүүлсэн. Нийцлийн аудитын төсөлд туссан зөрчлийн тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Дараах баримт бичгийг хавсаргав. Үүнд:

- Байр наадмын талбайн засварын ажлын гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороо байгуулсан аймгийн Засаг даргын 2018 оны 439 дүгээр захирамжийн хуулбар,
- Баяр наадмын талбайн засварын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хуулбар, цахим тендерийн урилга, үр дүн, нээлтийн тэмдэглэлийн хуулбар,
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтын хуулбар,
- Аймгийн ИТХ-ын хурлын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын хуулбар,
- Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 129 дүгээр тогтоолын хуулбар,
- “Мэдээлэл холбоо, сүлжээ” ТӨХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын даргын 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1/57 тоот албан бичгийн хуулбар, техникийн нөхцлийн хуулбар,
- Ажлын даалгаврын хуулбар
- “Арбель Алтай” ХХК-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний хуулбар,
- “Криетив Монголия” ХХК-тай байгуулсан залруулсан гэрээний хуулбар.

Хавсралт хуудастай.

ДАРГА

Б.БОЛД



001760955
01/А4

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020 оны
Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын
2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
1/968 дугаар албан бичгийн хавсралт

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСЛИЙН САНАЛ

№	Нийцлийн аудитын тайлангийн төслийн санал	Байгууллагын санал
1.	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Баяр наадмын талбайн засварын ажил”-ын 124,4 сая төгрөгийн нэмэлт ажлыг 2018 онд ХАА зохион байгуулалгүйгээр “Хөвсгөл эх” ХХК-иар гүйцэтгүүлсэн байна. ТАХ-ний санхүүжилтийг олгох зорилгоор 2019 онд ХАА-г зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 6 дугаар зүйлийн 6.1 ¹⁸ , 45 дугаар зүйлийн 45.1 ¹⁹ дэх заалттай нийцээгүй байна.	“Баяр наадмын талбайн засварын ажил”-ын 199,1 сая төгрөгийн төсвийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан. Аймгийн Засаг даргын 2018 оны 2 сарын 14-ний өдрийн А/99 дүгээр захирамжаар уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороог байгуулан худалдан авах ажиллагааг 2018 онд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим сайтаар зохион байгуулсан. Тендерт “Хөвсгөл суварга” ХХК, “Сайрын харгана” ХХК, “Хөвсгөл булаг” ХХК, “Хөвсгөл эх” ХХК оролцсон. “Баяр наадмын талбайн засвар ажил”-ын гүйцэтгэгчээр “Хөвсгөл эх” ХХК шалгарч, засварын ажлыг гүйцэтгэсэн. Мөн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 1.7-д Баяр наадмын талбайн засвар /нэмэлт ажил/ гэж баталж, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 4/192 тоот албан бичгээр тендер шалгаруулалтыг зохион байгуулж өгнө үү гэх хүсэлтийн дагуу, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх хэсэгт заасны дагуу гэрээ шууд байгуулах нөхцөл үүсээгүй тул тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Иймд “Баяр наадмын талбайн засварын ажил”-ын гүйцэтгэгч сонгох худалдан авах ажиллагааг 2018 онд зохион байгуулаагүй гэснийг нийцлийн аудитын тайлангийн төслөөс хасуулах саналтай байна.
2.	Жаргалант, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Шинэ-Идэр, Арбулаг, Улаан-Уул, Их-Уул, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Тариалан сумдад болон Хатгал тосгоны гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлын ХАА-ны үнийн санал ирүүлэх хугацааг 7 хоног хүрэхгүй хугацаанд тогтоосон байгаа нь	Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор зөвлөх үйлчилгээний шууд худалдан авалтын босго үнийг 10.0 сая төгрөг хүртэл болгон шинэчлэн тогтоосон. Зөвлөх үйлчилгээний шууд худалдан авалтын аргыг хэрэглэсэн үед гүйцэтгэгч шалгаруулах хугацааг хууль болон холбогдох журмын хүрээнд зохицуулаагүй. Жаргалант, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Шинэ-Идэр, Арбулаг, Улаан-Уул, Их-Уул, Цэцэрлэг, Чандмань-Өндөр,

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитын тайлан

НАГ-2020/02/НА

	ТБОНӨХБАҮХАТХуулийн 36 дугаар зүйлийн 36.6²⁰, 36.10²¹ дахь заалтуудтай нийцээгүй байна.	Тариалан сумдад болон Хатгал тосгоны гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний батлагдсан төсөв 10,0 сая төгрөг хүрээгүй тул зөвлөх үйлчилгээний шууд худалдан авалтын аргыг сонгож Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж зохион байгуулсан. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бараа, ажил, үйлчилгээний шууд худалдан авалтын аргыг хэрэглэж байгаа үед шууд худалдан авалтын урилга нийтлэх боломжгүй байдаг. Шууд худалдан авалтын үед гүйцэтгэгчийг шууд сонгож гэрээ байгуулах боломжтой бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчөөгүй, мөн гүйцэтгэгч шалгаруулах хугацааг 7 хоногоор тогтоосон гэх зөрчил биш тул нийцлийн аудитын тайлангийн төслөөс хасуулах саналтай байна.
3.	Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын ХАА-нд зураг, төслийн техникийн нөхцлийг боловсруулсан компани оролцсон нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 11 дүгээр зүйлийн 11.2¹¹ дахь заалттай нийцээгүй.	Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын зураг төсөв боловсруулахад шаардлагатай техникийн нөхцлийг "Мэдээлэл холбоо, сүлжээ" ТӨХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбарын даргын 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1/57 тоот албан бичгээр аймгийн Цагдаагийн газарт хүргүүлсэн байна. Уг төсөл, арга хэмжээнд шаардлагатай техникийн нөхцлийг орон нутгийн хувьд "Мэдээлэл холбоо, сүлжээ" ТӨХК-ийн Хөвсгөл аймаг дахь салбараас өөр байгууллага гаргаж өгөх боломжгүй юм. Мөн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын замын камер суурилуулах ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт боловсруулагдан аймгийн Засаг даргаар батлуулж аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлсэн. Техникийн нөхцөл олгох нь зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт хамааралгүй бөгөөд техникийн нөхцөлд хаагуур шугам татахад холбооны шилэн кабелийг дайрахгүй байх, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар туссан байдаг. Ажлын даалгаврын хүрээнд Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг зохион байгуулан гүйцэтгэгчээр "Арбель Алтай" ХХК шалгарч, зураг төсвийг боловсруулсан. Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахдаа зураг төслийн хүрээнд тендерийг зохион байгуулсан бөгөөд ажлын даалгавар, зураг төсөлд техникийн нөхцлөөс огт тусаагүй тул

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитын тайлан

НАГ-2020/02/НА

		Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын ХАА-нд зураг, төслийн техникийн нөхцлийг боловсруулсан компани оролцсон нь гэснийг нийцлийн аудитын тайлангийн төслөөс хасуулах саналтай байна.
4.	Их-Уул сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл боловсруулах ХАА-нд 2,8 сая төгрөгийн үнийн санал шалгарч дээрх үнийн дүнгээр гэрээ байгуулах зөвлөмж хүргэгдсэн байхад 3,0 сая төгрөгөөр гэрээг байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 ²³ дахь заалттай нийцээгүй.	Их-Уул сумын гудамжны гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч “Криетив Монголия” ХХК-тай байгуулсан гэрээний дүнг 2,800,000 болгож алдааг залруулсан. Гэрээний дүнг залруулсан тул уг алдааг тайлангийн төслөөс хасч өгнө үү.

Санал-2

Тайлбар бичсэн: Худалдан авах ажиллагааны албаны дарга  3.Гал-Эрдэнэ

Худалдан авах ажиллагааны албаны
ахлах мэргэжилтэн

Ц.Эрдэнэбаатар

Холбогдох байгууллагуудын саналд өгөх тайлбар

Санал-1: Саналыг хүлээн авах боломжгүй болно.

Санал-2: Саналыг хүлээн авах боломжгүй болно.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/23

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/53 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаалын тавдугаар хавсралтын 2.4, 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Мөнгөнхуяг/, аймгийн Засаг дарга /Л.Ганболд/, аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Аззаяа/, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт зөвлөсүгэй.

4. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Нийцлийн аудитын албаны аудитор /Н.Гүрбазар/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерийн албан үүрэг түр орлон гүйцэтгэгч /Э.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.ГАНБОЛД

Монгол Улс, Хөвсгөл аймаг – 6700, Мөрөн сум 8 дугаар баг
Аймгийн Засаг даргын Тамгын газрын “А” корпус
Утас: 7038-4043, 7038-4046, 7038-4793
И-мэйл: Khuwsgul@audit.gov.mn
Веб сайт: audit.mn/?page_id=579